



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга  
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 2017 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтын дүнг хэлэлцээд ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 2017 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ерөнхий захирал Х.Бадамсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

2.2. Худалдан авах ажиллагааны зөрчил, дутагдал гаргаж ажилласан үнэлгээний хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох;

2.3. Компанийн хөрөнгийг зохистой удирдах, авлага, өглөгийг бууруулах, хугацаа хэтэрсэн авлагыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх;

2.4. Ашиглалтгүй байгаа үндсэн хөрөнгийг худалдах болон шилжүүлэх асуудлыг судалж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлэх;

2.5. Компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, ажил үүргийн хуваарийг шинэчлэн батлуулах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх;

2.6. Мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах, эрх шилжүүлэх талаар гаргасан “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ерөнхий захирлын 2016 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/458 дугаар тушаалыг хүчингүй болгох арга хэмжээ авах;

2.7. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах болон энэхүү тогтоолоор өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах, биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001575

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2018 оны 04 дугаар сарын 14-ний өдрийн  
87-дугаар тогтоолын хавсралт

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 2017 оны шалгалтаар илэрсэн зөрчил,  
дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах нэгж	Дүн /сая төгрөг/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн зөрчил	Ерөнхий захирал, Санхүү, бүртгэлийн хэлтэс	7,797.3	Батлагдсан төлөвлөгөөний дагуу үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл авах
2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 19, 33, 34, 44, 46, 48 дугаар зүйлд заасныг зөрчиж худалдан авалт хийсэн зөрчил	Ерөнхий захирал, Үнэлгээний хорооны гишүүд, Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ажиллагсад	142,122.19	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж, төлөвлөгөөг хуулийн хугацаанд ил тод нээлттэй мэдээлэх, босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалт зарлах, нийт төсөвт өртгийг үндэслэх, урилгыг цахим веб хуудасанд зарлах, харьцуулалтын аргыг хэрэглэх, жишиг баримт бичиг ашиглах, урьдчилгаа төлбөрийг нөхцөл шаардлагын дагуу өгөх, үнэлгээг зааврын дагуу хийх, тайланг бүрэн гүйцэтгэд боловсруулах
3	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэж заасныг зөрчиж хандив өгсөн зөрчил	Ерөнхий захирал, Тэргүүн дэд захирал, Санхүү, бүртгэлийн хэлтэс	72.3	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүй хандив, зээл, тусламж өгөхгүй байх
<b>Зөрчил, дутагдлын нийт дүн</b>				<b>149,837.79</b>